



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 15

Сүхбаатар сум


Нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2, 2020 оны Төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 141 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцэн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Энхбатын Ариунааг Хушаат сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Шийдвэрийг холбогдох газарт хүргүүлж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Ариундэлгэр/-д даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА